

Чилика-ийн уриалал

2005 оны 2 сарын 6-аас 9-нд Энэтхэгийн Ориса мужийн Бубанесвер хот, Чилика нууранд зохиогдсон “Азийн Ус Намгархаг газрын Симпозиум-2005” –д оролцсон 32 орны 400 гаруй хүн дараах уриалалыг гаргаж байна.

Азийн Ус намгархаг газар нь ус намгархаг газрын натурал байдал, түүний үүргээс шалтгаалан биологийн төрөл зүйлийн үр шимийг хүн төрөлхтөнд өгч, амьдралыг нь дэмжиж ирсэн. Гэвч хүн амын өсөлт, ус намгархаг газрын үнэ цэнийг дутуу ухамсарласнаас Азийн ус намгархаг газар доройтож, нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлж байна. Бүхэлд нь бус хэсэгчилсэн хөгжил, ядуурал, ус намгархаг газрыг сэргээх явц болон хамгаалалт нь зохистой бус, хангалтгүй үйл ажиллагаа явуулж байгаа зэрэг асуудлаас үүдэн даруй арга хэмжээ авах хэрэгтэй болоод байна.

ОУ-ын байгууллага, дотоодын байгууллага, хувь хүмүүс сүлжээ байгуулан Азийн ус намгархаг газрын хамгаалалт болон зохистой хэрэглээг дэмжих механизмыг бүрдүүлж 1992 он (Ооцү, Күширо) болон 2001 онд Пенаны “Азийн Ус намгархаг газрын Симпозиум” –аар дэвшүүлэгдсэн мэдээлэлд үндэслэн шинэ бодлого, харилцаа, орон нутгийн эвсэл холбоонд суурилсан хяналтыг явуулж байгаа нь Азийн орнууд мэдлэг, туршлагаа нэгтгэн явуулсанаар бодитоор хэрэгжиж байна.

Чилика нуур нь нутгийн иргэдийн оролцоо, орон нутаг, дотоод болон ОУ-ын сүлжээнд орж, дундын эзэмшил, бодлого шийдвэрийг анхаарч ус намгархаг газрыг бүхэлд нь хамарсан хяналтын дүрмийг мөрдсөн учраас зохистой хамгаалалт, зохистой хэрэглээний үлгэр жишээ ус намгархаг газар болж чадсан юм. Хэрэгжүүлсэн ус намгархаг газрыг хамгаалах арга хэмжээ нь экосистемийг хадгалах, Чилика нууранд түшиглэн амьдардаг орон нутгийн хүмүүсийн харилцаа нийгэм эдийн засгийн байдлыг өргөн хүрээтэйгээр сайжруулсан.

2004 оны 12 сард Энэтхэгийн далайд болсон Цүнами-ийн уршгаар эргийн байгаль орчин эвдэрч, хүний ахуй амьдралд асар их хэмжээний хохирол учруулсан. Халуун бүсийн ширэнгэ ой, далайн ургамлын төрөл зүйл, шүр зэрэг эвдэрч элэгдсэн эргийн ус намгархаг газрыг нөхөн сэргээх шинэ асуудал тулгараад байна.

Дээрх асуудлуудад тулгуурлан бид дараах саналыг дэвшүүлж байна.

Ус намгархаг газрыг доройтуулах, тогтвортой бус хөгжлийн үйл ажиллагааг шууд зогсоох, дахиж явуулахгүй байх, ус намгархаг газрын экосистемийг хамгаалах болон нөхөн сэргээх, түүнчлэн орон нутгийн харилцаа, амьдрал ахуйг сайжруулахын тулд бодлого, арга барилыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ус намгархаг газарт түшиглэдэг орон нутгийн хувьд чухал ач холбогдол бүхий ус намгархаг газрын соёлын үнэ цэнийг мэдэрч хамгаалах ажлыг бодитоор хэрэгжүүлэх ёстой. Ядуурлыг арилгах, тогтвортой амьдралын үүсвэр, ус намгархаг газрын экосистем судлал болон нийгэм эдийн засгийн ухааны үнэ цэнийг хөгжлийн төлөвлөгөөнд голлон тусгах хэрэгтэй байна.

Үүнд, доорх үйл ажиллагааг санал болгож байна.

Ус намгархаг газрыг хадгалж хамгаалах ажлыг дэмжиж, хүн амын тогтвортой амьдралыг

баталгаажуулахын тулд дараах зүйлийг анхаарч, экосистемийг дээдэлсэн шинэ онолууд дэвшүүлж байна.

- ✓ Ус намгархаг газрын экосистемийн үүргийг баталгаажуулахын тулд хүрээлэн буй орчны зохистой хамгаалах явдал.
- ✓ Нутгийн иргэдийн уламжлал, мэдлэг, оюун ухааныг тусгасан, ус намгархаг газрын нөөц баялагийн биологийн төрөл зүйлийн хамгаалалт, зохистой хэрэглээг дэмжих.
- ✓ Ус намгархаг газрыг хадгалж хамгаалах үндэс нь ус намгархаг газрын соёлын өв, үнэ цэнийг таниулах явдал бөгөөд иргэдийн оролцоо, дэмжлэг зайлшгүй.
- ✓ Уламжлалт мэдлэгт тулгуурлан эко туризмыг хамарсан хүрээлэн буй орчинд нөлөөгүй эко үйл ажиллагаагаар нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих. Нэмэлт орлого олсоноор ус намгархаг газрын нөөц баялагт үзүүлэх дарамтыг багасгаж чадах ба ус намгархаг газарт үзүүлэх нэмүү өртөгийг тооцох нийгмийн харилцааг хөгжүүлэх.
- ✓ Ус намгархаг газрыг хадгалж хамгаалах төлөвлөгөө, шинэ хөтөлбөр боловсруулж, эдгээр хөтөлбөр амжилттай хэрэгжих эсэх нь тухайн улс, орон нутгийн сонирхлын хэрэгцээнд нийцсэн арга хэрэгсэл, материал, бүтээгдэхүүн бий болгож түгээх.
- ✓ Ус намгархаг газрын тогтвортой хөгжлийг баталгаажуулахын тулд салбар тус бүрээр хөгжиж ирсэн хөгжлийн хөтөлбөрүүдийн бүхий л шатанд ус намгархаг газрыг цөм нь болгон авч үзэх шаардлагатай.
- ✓ Ус намгархаг газрыг зохистой хэрэглэхийн тулд хадгалж хамгаалах бодлого, төлөвлөгөө, стратеги боловсруулах.
- ✓ Ус намгархаг газрыг хадгалж хамгаалах амжилттай туршлагыг авч хэрэглэх, дэмжих, хөгжүүлэн орон нутаг, улс, газар нутгийн түвшинд нь нэвтрүүлэх.
- ✓ Ус намгархаг газрын тогтвортой хамгаалалтын талаар хүмүүсийн мэдрэмж, оролцоог өөрчлөх үндэс суурь болгож боловсрол, сургалтыг эн тэргүүн байр сууринд тавих.
- ✓ Ус намгархаг газрын байцаагч, бодлого боловсруулагчид, төлөвлөгчид, хэрэгжүүлэгчид, хэвлэл мэдээлэлийнхэн, шийдвэрлэгчид болон орон нутгийн харилцагчидын чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг чанаржуулж, хэрэгжүүлэх.
- ✓ Нутгийн иргэдийн аж амьдралыг тогтвортой байлгахын тулд ус намгархаг газрын экологийн байдал ба түүний өгөөмжийг тогтворжуулж, ус намгархаг газрыг нөхөн сэргээх.
- ✓ Цүнами-ийн хохиролыг амссан газар нутгийн хүмүүсийн тогтвортой амьдралыг эргэн сэргээхийн тулд хохирол амссан нутгийн эргийн ус намгархаг газрын нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэсэн шуурхай арга хэмжээ авах явдал.

Зохион байгуулагч нь Энэтхэг улсын Засгийн газар болон Япон улсын Засгийн газарт хандаж ойрын хугацаанд зохиогдох Рамсарт Конвенцийн Азийн бүс нутгийн холбоо болон 2005 оны 11 сард Недарландийн Канпара-д болох Рамсарын Конвенцийн Талуудын 9-р чуулга, мөн 2005 оны 11 сард Кения-ийн Найроб-д болох Талуудын 11-р чуулга уулзалтад энэ уриалалыг дамжуулах ба түүнийг удирдаж дэмжихийг хүсч байна.

2005 оны 2 сарын 9 Бубанесвер